



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
ТАТВАРЫН ХЭЛТСИЙН ДАРГЫН  
ТУШААЛ

2020 оны 06 сарын 15 өдөр

Дугаар 4/15

Арвайхээр

Үр дүнгийн урамшуулал олгох тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Засгийн газрын 2019 оны "Журам батлах тухай" 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 1.2, 1.2.2, 2.2 дахь заалт, Татварын хэлтсийн даргын 2016 оны А/01 дүгээр тушаалаар батлагдсан "Хөдөлмөрийн дотоод журам"-ын 7 дугаар зүйлийн 7.16 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. 2020 оны 2 дугаар улирлын үйл ажиллагааны төлөвлөгөөг давуулан биелүүлэхэд идэвхи зүтгэлтэй ажилласан татварын улсын /ахлах/ байцаагч, ажилтнуудад үр дүнгийн урамшуулал олгосугай.

2. Татварын улсын /ахлах/ байцаагч, ажилтнуудад 2020 оны 2 дугаар улирлын үр дүнгийн урамшууллыг хавсралтад дурдсан хувиар албан тушаалын цалингаас тооцож олгохыг нягтлан бодогч /О.Отгончимэг/-д зөвшөөрсүгэй.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, хуулийн тасгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /А.Ганчимэг/-д үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Н.ЭРДЭНЭСУВД



106181029